



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/121.

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах, зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам"-д дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

а. Журмын 1.1 дэх заалтыг "Авто замын норм, нормативын сан /цаашид "Сан" гэх/-ийн журмын зорилго нь Монгол Улсын авто зам, автотээвэр, төмөр зам, иргэний нисэхийн аэродром, хөөрч буух зурвас, замын байгууламжийн норм, норматив, техникийн баримт бичиг, стандарт, судалгааны ажил боловсруулах, батлуулах, хэвлэж олшруулах, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянах үйл ажиллагааг зохицуулахад оршино." гэж өөрчлөх;

б. Журмын 1.2, 1.3, 2.1, 2.3.2, 2.3.3, 2.8.2, 2.10.1, 2.10.2, 2.11.3, 2.11.4, 2.11.6, 2.11.7, 2.11.8, 2.11.9, 3.2, 4.1.1, 4.1.2, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7 дахь заалтын "авто зам" гэсний дараа "автотээвэр, төмөр зам, иргэний нисэхийн аэродром, хөөрч буух зурвас" гэж нэмэх;

в. Журамд "1.8. Салбарын норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд зам, тээврийн салбаруудаас төвлөрөх орлогын хэмжээтэй уялдуулан зарцуулах зарчмыг баримтална." гэсэн заалтыг нэмсүгэй.

2. Сангийн Удирдах болон Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Санд хөрөнгө төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Загдраднаа/, Бодлого, төлөвлөлтийн газар /Д.Гэрэлням/, Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ё.Жаргалсайхан/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Мөнхтуяа/, Зам, тээврийн хөгжлийн төв" Төрийн өмчит үйлдвэрийн газар /Р.Буд/-т тус тус даалгасугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/М.Энхболд/-т үүрэг болгосугай.

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2020 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн
#112/ дугаар тушаалын хавсралт



САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Дэд дарга “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал
- Нарийн бичгийн дарга: “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм нормативын хэлтсийн дарга
- Гишүүд:
- Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч
 - Нийслэлийн авто замын хөгжлийн газрын дэд дарга
 - Авто замын салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

САНГИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хариуцсан шинжээч
Гишүүд:	<p>Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Авто замын салбарын бодлого, хөтөлбөр, төслийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан шинжээч</p> <p>Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн шинжээч</p> <p>Авто замын салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл (зөвшилцсөнөөр)</p>

